



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ


Нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 2015 онд давхардсан тоогоор 2030.2 мянган хүн үйлчлүүлсэн байна. Нийт үйлчлүүлэгчдийн 25.8 хувийг нийгмийн даатгалын 5 төрлийн даатгалд даатгуулсан иргэд, 38.9 хувийг төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлсөн иргэд, 10.1 хувийг эмчилгээ үйлчилгээний зардал болон эмийн үнийн хөнгөлөлт эдэлсэн иргэд, үлдсэн 25.2 хувийг тэтгэвэр, тэтгэмж авагчид болон сайн дурын даатгуулагчид эзэлж байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн тоо

Үзүүлэлт		2013 он	2014 он	2015 он
Бүгд		1757769	2044822	2030240
Үүнээс	НД-ын 5 төрлийн даатгалд заавал даатгуулагчийн тоо	521863	549478	523784
	НД-д сайн дураар даатгуулагчийн тоо	70326	88672	95072
	ЭМД-д заавал болон сайн дураар даатгуулагчийн тоо	141757	150023	149331
	Тэтгэвэр авагч иргэдийн тоо	125912	139769	147816
	Тэтгэмж, төлбөр авагч иргэдийн тоо	103308	115217	117979
	ЭМД-ын шимтгэлийг төрөөс төлдөг иргэний тоо	617357	806477	790703
	Эмчилгээ үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон иргэдийн тоо	177246	195186	205555

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 96.0 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 739.9 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Зураг 1. Даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөг, оноор



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.9 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 18.9 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.3 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.1 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд, 1.8 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Энэ онд нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 768.2 мянган хүн хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлжээ. Нийт шимтгэл төлөгчдийн 68.2 хувийг нийгмийн даатгалын таван төрлийн даатгалд заавал даатгуулагчид, 31.8 хувийг эрүүл мэндийн даатгал болон сайн дурын даатгалд даатгуулсан иргэд эзэлж байна.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, дүүргээр, сая төгрөгөөр

	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Багануур	4894.3	6050.3	8032.5	10143.8	10695.0	12046.7
Багахангай	407.6	579	689.3	979.2	1055.1	1188.9
Баянгол	46528.4	65555.3	92660.4	117806.4	134268.8	137736.4
Баянзүрх	29635.7	41336.9	60417.8	78100.9	92135.1	99744.9
Налайх	2214.2	2960.6	4315.2	5935.8	7009.0	7166.2
Сонгинохайрхан	14837.6	19831.2	29421.3	41640.7	49288.8	51660.3
Сүхбаатар	59912.2	94303.6	134907.6	157746.3	168632.0	170277.7
Хан-уул	32717.7	47651.2	65634.7	84788.1	98280.8	100285.0
Чингэлтэй	42546	68094.8	112957.1	136249.9	153246.0	159847.5
Нийслэлийн НДГ	4162.3	3969.4	2590.7	116.4	45.2	0.0
Нийт дүн	237856.0	350332.3	511626.6	633507.5	714655.8	739953.6

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төгрөгөөр

Сангийн төрөл	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Тэтгэврийн даатгал	157077.5	195803.5	321734.0	374450.4	446386.9	529434.8
Тэтгэмжийн даатгал	12838.3	17450.3	24916.7	35412.2	48202.3	53635.9
Эрүүл мэндийн даатгал	45155.6	50878.8	66917.5	4245.9	5443.4	5778.6
ҮОМШӨ-ний даатгал	6595.6	7922.7	11684.3	12972.0	13307.3	13519.0
Ажилгүйдлийн даатгал	5486.4	4276.6	4311.7	8544.7	12451.7	15648.7
Нийслэлийн дүн	227153.4	276331.9	429564.2	435625.2	525791.6	618017.0

Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ онд даатгуулагч, иргэдэд нийт 618.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээ, үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 85.7 хувийг тэтгэврийн, 0.9 хувийг эрүүл мэндийн, 2.2 хувийг ҮОМШӨ-ний, 8.7 хувийг тэтгэмжийн, 2.5 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас сард дунджаар 147.8 мянган хүнд тэтгэвэр олгосон бөгөөд олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 528.8 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 74.4 хувийг өндөр насны, 10.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 11.8 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.